



АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/21

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 14.3, 14.5 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 2.7 дахь заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 4.8, 4.8.1, 4.8.8 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ийг хавсралтаар баталсугай.

2. Журмыг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдлөг болгож хэрэгжилтийг ханган ажиллахыг Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга (С.Хандмаа), Оюутны хөгжил, удирдлагын газрын дарга (Д.Оюунбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал (Я.Энхтөр, Г.Дарамбазар, Д.Цэнд-Аюуш, Б.Батбаяр, Д.Даваалхам, Б.Оюунгоо, Д.Даваадагва), салбар сургуулийн захирал (Б.Баясгаланмөнх, Д.Гүндэгмаа, М.Отгончимэг), тэнхимиийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Журам батлах тухай Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/125 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга (Г.Батбаатар), хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Б.Зоригбаатар) нарт тус тус даалгасугай.

РЕКТОРЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДАМДИНДОРЖ



Анагаахын шинжлэх ухааны үндэсний  
их сургуулийн Ректорын үүрэг гүйцэтгэгчийн  
2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн  
1/21 дугаар тушаалын хавсралт



## Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

- Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн актууд болон Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (АШУҮИС) дүрмийн хүрээнд төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах, сургалтын чанарын удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- Төгсөлтийн өмнөх сургалт нь сургалтын чиглэл, түвшин бүрээр батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийн дагуу явагдана. Их сургуулийн сургалтын эхлэх, дуусах хугацааг тухайн хичээлийн жил нэгдсэн байдлаар тогтооно.
- Дээд боловсолын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

### Хоёр. Сургалтын үйл ажиллагаа

- Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулах газар (ТӨСБЗГ), Оюутны хөгжил, удирдлагын газар (ОХУГ) нь АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулах, оюутны суралцаж үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажиллана.
- Төгсөлтийн өмнөх сургалтад бакалавр, дэд бакалавр хөтөлбөрүүд хамаарах ба хөтөлбөр тус бүрээр сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.
- Бакалаврын болон дэд бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулгыг судалсан багц цагаар тогтооно.
- Хамтарсан хөтөлбөр, шаталсан хөтөлбөр, бакалавр-магистрын нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг батлах үйл явц, хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт нь бусад хөтөлбөртэй ижил байна.
- ТӨСБЗГ-аас хичээлийн жилийн эхэнд тухайн хичээлийн жилийн сургалтын ачааллыг төлөвлөж, Боловсрол хариуцсан проректор батална. Сургалтын төлөвлөгөөг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулиуд сургалтыг зохион байгуулна.
- Оюутны бүртгэл, хэсгийн хуваарилалт
  - Оюутныг поток, дамжааны зохион байгуулалттай хэсгүүдэд хуваарилна.
  - Анги дэвших оюутны нэрсийг баталгаажуулж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал 8-р сарын 30-ны дотор суралцах эрхийг нээх ба суралцах эрх нээгдээгүй оюутныг хичээлд оролцуулахгүй.
  - Шинээр элссэн оюутныг 8-р сарын 25-ны дотор АШУҮИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна.
- Анги дэвшин суралцахад тавих шаардлага
  - Оюутан нь сургалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж, амжилттай үнэлүүлсэн байх;
  - Сургалтын төлбөрийн тооцоогүй байх.

- 2.8. Гадаад, дотоодын ижил мэргэжлийн сургуулиас шилжин ирсэн болон сургалтаас түр чөлөөлөгдсөн суралцагчид хөтөлбөрийн багц цагийн зөрүүг өвөл, зуны сургалтаар судлах ба бусад тохиолдолд үл тооцов үнэлгээ авсан тохиолдолд танхимын, танхимын бус, цахим сургалтаар нөхөн суралцана.
- 2.9. Оюутанд хичээлийн нэг өдрийн чөлөөг хичээл удирдаж буй багш, 2-5 өдрийн чөлөөг бүрэлдэхүүн сургуулийн аргазүйч, блокийн зохицуулагч, түүнээс дээш өдрийн чөлөөг хүндэтгэх шалтгааныг нотолсон баримтыг үндэслэн ОХУГ олгоно.
- 2.10. Төгсөлтийн өмнөх сургалтад хамрагдаж буй суралцагчдын танилцах, эмнэлзүйн, технологийн, хээрийн дадлагыг Оюутны дадлагын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 2.11. Бакалавр-магистрын нэгдмэл агуулгатай хөтөлбөрт дараах шаардлага хангасан суралцагч өөрийн хүсэлтээр элсэн суралцуулна. Үүнд:
  - 2.11.1 Суралцсан 10 улирлын голч дүн 3.3-аас дээш байх;
  - 2.11.2 Сургалтын хөтөлбөрийн багц цагийн зөрөөгүй байх;
  - 2.11.3 Сургалтын төлбөрийн үлдэгдэлгүй байх;
  - 2.11.4 Ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;
  - 2.11.5 Суралцах хугацаандаа "Үл тооцов" үнэлгээ авч байгаагүй
- 2.12. Бакалавр-магистрын нэгдмэл агуулгатай хөтөлбөрт суралцагч судалгааны ажил, судалгааны төсөлт ажил бичиж хамгаалах ба төгсөлтийн шалгалтын удирдамжийн дагуу зохицуулна..

### **Гурав. Сургалтын хөтөлбөр**

- 3.1. Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага, сургалтын арга зүй, үнэлгээ, сайжруулалтын төлөвлөлт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, элсэгч, төгсөгчид тавигдах шаардлагыг тусгасан цогц баримт бичиг байна.
- 3.2. АШУҮИС-д шинээр элсэгчид Анагаахын суурь боловсролын дамжаа (АСБД), Эрүүл мэндийн суурь боловсролын дамжааны (ЭМСБД) сургалтын хөтөлбөр болон бусад мэргэжлийн сургалтын хөтөлбөрт суралцана.
- 3.3. АСБД-ны хөтөлбөрт Хүний их эмч, Монгол анагаах ухааны их эмч, Шүдний их эмч, Хүүхдийн эмч хөтөлбөрөөр элсэгчид, ЭМСБД-ны хөтөлбөрт Эм зүйч, Био-анагаах судлаач, Нийгмийн эрүүл мэнд судлаач, Эрүүл ахуйч, тархвар судлаач хөтөлбөрөөр элсэгчид суралцана.
- 3.4. Суурь сургалтын багц цагийг судалсан, голч дүн 1.7 ба түүнээс дээш үнэлүүлсэн тохиолдолд анги дэвшин суралцах эрх нээгдэнэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй бол суурь дамжааны сургалтын хөтөлбөрт суралцсан гэрчилгээ олгох ба голч дүнгийн жагсаалтаар дэд бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах боломжтой.

### **Дөрөв. Үнэлгээний аргачлал**

- 4.1. АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн хөтөлбөрийн хүрээнд суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах, бүтээлч хандлагыг дэмжих, оюутны мэдлэг, чадвар, хандлагыг бодитой, ил тод, нээлттэй зарчмаар үнэлэхэд чиглэнэ.
- 4.2. Оюутныг хичээлээр олгох суралцахуйн үр дүнг хэрхэн эзэмшсэн байдлаар хамааруулан хувьчилсан оноогоор үнэлж, үсгээр болон тоогоор илтгэсэн дүнг харгалзуулна (Хүснэгт.1). Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны оноо болон голч дүнг ИСҮМС-ийн

дэх хичээлийн дүнг үндэслэн тооцох ба Төрийн захиргааны төв байгууллагаас голч дүн тооцох аргачлалаар тооцно.

4.3. Оюутны үнэлгээ хичээлийн явц, төгсгөлийн шалгалтын дүнгийн нийлбэрээс бүрдэх бөгөөд 70:30 харьцаатай байна.

Хүснэгт.1 Процентон дүнд харгалзах чанарын оноо

Процентон үнэлгээ	Үсгээр илэрхийлсэн үнэлгээ	Тоогоор илэрхийлсэн үнэлгээ (голч дүн)
95-100	A	4.0
90-94		3.7
87-89	B	3.3
83-86		3.0
80-82		2.7
77-79	C	2.3
73-76		2.0
70-72		1.7
65-69	D	1.3
60-64		1.0
0-59	F, W, WF	0

4.4. Хичээлийн явцын үнэлгээ нь (70%) мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхээс гадна хичээлийн даалгаврын биелэлт, оролцоо, ирцээс бүрдэнэ.

4.5. Дараах тохиолдолд явцын үнэлгээг “Үл тооцов” гэж үнэлэх ба шалгалтад орох эрхгүй.

4.5.1. Хичээлийн явцын дүн 60%-аас бага;

4.5.2. Блок сургалтын хувьд хичээл тус бүрийн явцын дүн 60%-аас бага;

4.5.3. Сургалтад хамрагдаагүй хичээлийг тогтоосон хугацаанд нөхөөгүй;

4.5.4. Хүндэтгэх шалтгаангүйгээр хичээлийн 25-аас дээш хувьд оролцоогүй.

4.6. Явцын үнэлгээний амжилт нь оюутныг шалгалтаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.7. Оюутан шалгалтыг (30%) заавал өгнө.

4.7. “Үл тооцов” үнэлгээ авсан тохиолдолд сургалтын багц цагийн төлбөрийн 50%-ийг төлж нөхөн суралцана.

4.8. Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхдээ шалгалтын дараах хэлбэрүүдийг сонгоно. Үүнд:

- Сорил
- Аман шалгалт
- Эссэ
- Эмнэлзүйн тохиолдол
- Төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалт
- Төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт
- Гардан шалгалт
- 360 хэмийн үнэлгээ
- Эмнэлзүйн дасгал үнэлгээ
- Гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ



- Бусад
- 4.9. Багш шалгалтаас хойш ажлын 2 өдөрт багтаан оюутны дүнг ИСУМС-д оруулж, дүнгийн хуудсыг хэвлэн тэнхимийн эрхлэгч, блокийн координаторын гарын үсгээр баталгаажуулан хариуцсан арга зүйчид хүлээлгэн өгнө.
- 4.10. Баталгаажуулсан дүнгийн хуудсыг үндэслэн аливаа маргааныг шийдвэрлэнэ.
- 4.11. Оюутны дадлагыг “Дадлагын удирдамж”-ийн дагуу үнэлнэ.
- 4.12. Суралцагч хичээлийн үнэлгээний талаарх санал, гомдоо Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого, зохицуулалтын газарт гаргах эрхтэй.
- 4.13. Суралцагч тухайн хичээл, блокийн дахин шалгалтыг зөвхөн 1 удаа өгөх эрхтэй ба нэг багц цагийн төлбөрийн 50%-ийг төлсөн байна.
- 4.14. ИСУМС-ийг үндэслэн дахин шалгалтад хамрагдах оюутны нэrsийг гаргах ба ТӨСБЗГ-аас баталсан хуваарийн дагуу тухайн улиралдаа багтаан зөвхөн 1 удаа зохион байгуулна.
- 4.15. Хүндэтгэх шалтгааны улмаас шалгалтад ороогүй бол шалгалтыг нөхөн өгнө.
- 4.16. Товолосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр шалгалтад ороогүй бол “F” үнэлүүлсэнд тооцно.
- 4.17. Дүн ахиулах зорилгоор шалгалт дахин өгөхийг зөвшөөрөхгүй.

#### Тав. Сургалтын төлбөр

- 5.1. АШҮҮИС-ийн бүх түвшний сургалтын хөтөлбөрт суралцагсад тухайн хичээлийн жилийн сургалтын багц цагийн төлбөрөө төлснөөр суралцах эрх нь нээгдэнэ.
- 5.2. Сургалтын төлбөр нь тухайн хичээлийн жилд судлах нийт багц цагийг, нэг багц цагийн төлбөрөөр үржүүлсэнтэй тэнцүү байна.
- 5.3. АШҮҮИС-д шинээр элссэн суралцагч 8 дугаар сарын 1-ний дотор, анги дэвшин суралцагч 8 дугаар сарын 20-ны дотор тухайн жилийн сургалтын төлбөрөө бүрэн төлсөн байна.
- 5.4. Сургалтын төлбөрийн мэдээллийг Санхүү, эдийн засгийн газар 8 дугаар сарын 25-ны дотор бүрэлдэхүүн сургуулийн арга зүйчид хүргүүлэх ба хөтөлбөрийн зөрүүгүй, хичээлийн тооцоогүй, сургалтын төлбөрийн үлдэгдэлгүй суралцагчдын суралцах эрхийг нээнэ.
- 5.5. Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан бол төгсөх дамжааны оюутанд төлбөрийн зөрүүг олгоно, харин үргэлжлүүлэн суралцаж буй тохиолдолд дараа жилийн сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно.

#### Зургаа. Оюутны шилжилт хөдөлгөөн

- 6.1. Гадаад, дотоодын их сургуулиас болон АШҮҮИС-д сургалтын хөтөлбөрт шилжин суралцах хүсэлтийг ОХУГ жилд 2 удаа хүлээн авч шийдвэрлэнэ.
- 6.2. АШҮҮИС-ийн тухайн жилийн элсэлтийн хяналтын тоо, хөтөлбөр бүрийн оюутны тоо, анги дүүргэлт зэргийг харгалzan зөвхөн суурь боловсролын дамжаанд (1, 2-р дамжаа) хөтөлбөр хооронд шилжилт хөдөлгөөн хийнэ. Хүсэлт гаргагч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
1. АШҮҮИС-ийн хөтөлбөр шилжих хүсэлтийн маягт
  2. Иргэний үнэмлэхийн лавлагаа (E-Mongolia)
  3. 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зураг
  4. Сургуулиас баталгаажуулсан судалсан багц цаг, дүнгийн тодорхойлолт

5. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж
  6. Бүх шатны боловсролын бичиг баримт (E-Mongolia)
- 6.3. Гадаадын их сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 6.3.1. Тухайн сургуульдаа хоёроос доошгүй улирал суралцаж, 24 багц цагаас багагүй хичээл судалсан байх;
  - 6.3.2. Судалсан хичээлийн голч дүн 2.8 ба түүнээс багагүй байх;
  - 6.3.3. Суралцах хугацаандаа судалсан хичээлийн тодорхойлолтыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
  - 6.3.4. Гадаад оронд ахлах сургууль төгссөн бол элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх (SAT гэх мэт) шалгалтын үнэлгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 6.4. Дотоодын их сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 6.4.1. Хоёроос доошгүй улирал суралцаж, 24 багц цагаас багагүй хичээл судалсан байх;
  - 6.4.2. Судалсан хичээлийн тодорхойлолт, голч дүн 2.8 ба түүнээс багагүй байх;
  - 6.4.3. Суралцаж байсан сургуулийн тодорхойлолт;
  - 6.4.4. Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) оноо нь тухайн хичээлийн жилийн АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрт элсэх босго оноонд хүрсэн байх;
  - 6.4.5. Дэд бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах бол нэгээс доошгүй улирал суралцаж, 12 багц цагаас багагүй хичээл судалсан байх, тухайн хөтөлбөрт шаардах ЭЕШ-ын босго оноонд хүрсэн байх.
- 6.5. АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөр хооронд шилжихэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 6.5.1. Суралцагч нь тухайн хөтөлбөрөөр хоёроос доошгүй улирал суралцаж, 24 багц цагаас багагүй хичээл судалсан байх;
  - 6.5.2. Суралцсан хугацааны голч дүн 2.8 ба түүнээс дээш байх;
  - 6.5.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) оноо нь тухайн хичээлийн жилд АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрт элсэх босго оноонд хүрсэн байх.
- 6.6. Тухайн хичээлийн жилд хөтөлбөр хооронд шилжин суралцах оюутны тоог ОХУГ тооцон гаргах ба багц цагийн зөрүүгүй, сургалтын төлбөрийг бүрэн төлсөн тохиолдолд анги хэсэгт хуваарилж, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 6.7. ОХУГ-ын саналыг үндэслэн суралцах эрхийг түр түдгэлзүүлэх, чөлөөлөх, сургуулиас бүрмөсөн чөлөөлөх шийдвэрийг, ТӨСБЗГ хянаж, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 6.8. Дараах тохиолдолд оюутны суралцах эрхийг түр түдгэлзүүлж, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 6.8.1. Зуны, үйлдвэрлэлийн дадлагыг удирдамжийн дагуу хийгээгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр тайлан хамгаалаагүй эсвэл хангалтгүй үнэлүүлсэн бол;
  - 6.8.2. Нэг улиралд 3 хичээл F үнэлүүлсэн эсвэл блокийн дахин шалгалтад F үнэлүүлсэн бол;
  - 6.8.3. Нэг улиралд 6 багц цагаас дээш хичээлийн хөтөлбөрийн шаардлага хангаагүй эсвэл хичээлд суугаагүй бол;
  - 6.8.4. ТЗЭШ, ТЗГШ-ыг 2 удаа хангалтгүй үнэлүүлсэн бол;
  - 6.8.5. Хөтөлбөрийн зөрүүг товлосон хугацаанд нөхөөгүй бол;
  - 6.8.6. Ёс зүй, харилцаа хандлагын зөрчил гаргасан нь тогтоогдсон бол;
  - 6.8.7. Сургалтын төлбөрөө төлөөгүй эсвэл төлбөрийн үлдэгдэлтэй бол.

- 6.9. Дараах тохиолдолд оюутныг нэг жилийн хугацаатай сургалтаас чөлөөлж, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
  - 6.9.1. Эрүүл мэндийн шалтгаан;
  - 6.9.2. Ар гэрийн гачигдал (өвчтэй хүн асарсан гэх мэт);
  - 6.9.3. Гадаад, дотоодын урт хугацааны сургалтад хамрагдах; (АШУҮИС-ийн гэрээтэй сургуульд)
  - 6.9.4. Жирэмсэн, хүүхэд асрах, өсгөх, тусгай хэрэгцээт;
  - 6.9.5. Олимп, дэлхий, тивийн болон олон улс, улсын чанартай тэмцээн, уралдаанд бэлтгэх, оролцох;
  - 6.9.6. Хугацаат цэргийн алба хаах;
  - 6.9.7. Байгалийн гамшигт нэрвэгдэх, хорио цээр тогтоогдсон газар хөл хоригдох болон бусад хүндэтгэх шалтгаан;
  - 6.9.8. Хүндэтгэх шалтгаангүй нэг улирлын хичээлд суугаагүй, улирлын хуваарыт шалгалтуудыг товлосон хугацаанд өгөөгүй бол,
- 6.10. Сургалтаас чөлөөлсөн, суралцах эрхээ түр түдгэлзсэн шалтгаанаа арилгасан тохиолдолд үргэлжлүүлэн суралцах хүсэлтээ ОХУГ-д гаргаж, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 6.11. Дараах тохиолдолд сургуулиас буюу сургалтаас бүр мөсөн чөлөөлөх, АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
  - 6.11.1. Суралцах хугацаанд 3 удаа суралцах эрхийг түр түдгэлзүүлсэн бол;
  - 6.11.2. Эрүүл мэндийн шалтгаанаар үргэлжлүүлэн суралцах боломжгүй бол;
  - 6.11.3. Суралцагчийн гэрээ, ёсзүйн дүрэм, бусад журмуудыг зөрчсөн бол;
  - 6.11.4. Гэмт хэрэгт холбогдсон нь шүүхийн байгууллагаар тогтоогдсон бол;
  - 6.11.5. Баримт бичиг хуурамчаар (оюутны үнэмлэх, дүнгийн хуудас гэх мэт засвар, нэмэлт бичилт хийсэн буюу хийлгэсэн бол;
  - 6.11.6. Өөрийн хүсэлтээр;
  - 6.11.7. Сургалтаас чөлөөлсөн хугацааг сунгаагүй бол;
  - 6.11.8. Сургалтын хөтөлбөрийг дур мэдэж сольж суралцсан бол;
  - 6.11.9. Суралцагчийн суралцах хугацаанд 3 жилээс илүү хугацаагаар сургалтаас завсардсан.

### Долоо. Төгсөлтийн шалгалт

- 7.1. АШУҮИС-ийн Ректорын тушаалаар “Төгсөлтийн шалгалтын зөвлөл” байгуулж, төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах ба төгсөгчдийн эзэмшсэн цогц чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-ийн түвшинг үнэлэхэд чиглэнэ.
- 7.2. ТӨСБЗГ-аас төгсөлтийн шалгалтын тов, шалгалтад орох оюутны нэрсийг гаргаж АШУҮИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 7.3. ТӨСБЗГ нь төгсөлтийн шалгалтын явцад хяналт тавьж, шалгалтын дүнд нэгдсэн үнэлгээ хийнэ.
- 7.4. Төгсөлтийн шалгалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил, санал, гомдлыг ТӨСБЗГ-т гаргахба тухайн өдөрт нь багтаан шийдвэрлэнэ.
- 7.5. Төгсөлтийн шалгалтын зөвлөл ерөнхий болон мэргэжлийн салбар зөвлөлөөс бүрдэнэ.
- 7.6. Төгсөлтийн шалгалтын ерөнхий зөвлөл нь төгсөлтийн шалгалтын дэгийг хэлэлцэж батална.
- 7.7. Төгсөлтийн шалгалтын Ерөнхий зөвлөлийн даргаар Боловсрол хариуцсан проректор, нарийн бичгийн даргаар ТӨСБЗГ-ын дарга, мэргэжлийн салбар зөвлөлийн даргаар бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлыг томилно.
- 7.8. Төгсөлтийн шалгалт нь сорил, дипломын ажил, судалгааны төсөл бичих, мэдлэг, ур чадварыг үнэлэх шалгалт, өртөөчилсөн гардан үйлдлийн шалгалт, төлөвлөгдсөн зорилгот эмнэлзүйн гардан гүйцэтгэх шалгалт зэрэг

хэлбэрүүдтэй ба сургалтын хөтөлбөрийн онцлогт тохируулан шалгалтын хэлбэрийг сонгоно.

- 7.9. Төгсөлтийн шалгалтын хэлбэр тус бүрийн удирдамжийг бүрэлдэхүүн сургууль боловсруулж, ТӨСБЗГ хянаж, Боловсрол хариуцсан проректор батална.
- 7.10. Төгсөлтийн шалгалтад 70 хувиас бага буюу D, F үнэлгээ авсан оюутныг "хангалтгүй" үнэлүүлсэнд тооцно.
- 7.11. Төгсөлтийн шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан оюутан дараагийн хэлбэрийн шалгалтад орох эрх нь нээлттэй.
- 7.12. Төгсөлтийн шалгалтаа хангалтгүй үнэлүүлсэн төгсөгч дараагийн хичээлийн жилд 1 удаа дахин шалгалтад орох эрхтэй.
- 7.13. Хүндэтгэх шалгаанаар төгсөлтийн шалгалтад ороогүй оюутан 2 жилийн дотор төгсөлтийн шалгалтаа өгөх эрхтэй.
- 7.14. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу төгсөгчдөд төгсөлтийн баримт бичиг олгоно. Үүнд:
- 7.14.1. Төгсөлтийн шалгалтын салбар зөвлөлийн шийдвэрийг үндэслэн бакалавр болон дэд бакалаврын зэргийн шаардлага хангасан төгсөгчдөд АШУҮИС-ийн Ректорын тушаалаар диплом, энгэрийн тэмдэг олгоно.
- 7.14.2. Бакалавр, дэд бакалаврын боловсролын зэрэг олгосныг гэрчлэх баримтад АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, АШУҮИС-ийн Ректор, Төгсөлтийн шалгалтын ерөнхий зөвлөлийн дарга болон бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, АШУҮИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба бүртгэлийн дугаартай байна.
- 7.14.3. Төгсөлтийн шалгалтын салбар зөвлөл нь их сургуулийн архивд төгсөж буй төгсөлтийн шалгалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэр, төгсөгчдөд диплом олгосон бүртгэл, дипломын болон дипломын хавсралтын хуулбарыг бүрдүүлж хүлээлгэн өгнө.
- 7.14.4. Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд нотлох баримтыг үндэслэн нөхөн олгоно.
- 7.15. Дараах болзол хангасан төгсөгчдөд онцгойлох диплом олгоно. Үүнд:
- 7.15.1. Бүх хичээлийн 75-аас дээш хувьд А үнэлэгдсэн, бусад хичээл В үнэлэгдсэн
- 7.15.2. Голч дүн нь 3.7 ба түүнээс дээш
- 7.16. АШУҮИС-ийн элсэгчдэд оюутны үнэмлэх олгоно.
- 7.17. Оюутны лавлагаа, тодорхойлолтын бүрэлдэхүүн, салбар сургууль, Төгсөлтийн өмнөх бодлого, зохицуулалтын газар, Оюутны хөгжил, удирдлагын газар тус тус олгоно (Хүснэгт.2).
- 7.18. Оюутны лавлагаа, тодорхойлолт, баримт бичгийн нөхөн олголтыг зөвхөн өөрт эсвэл эцэг эх, эхнэр, нөхөрт олгох ба холбогдох журмын дагуу хураамж төлнө.

#### Хүснэгт.2 Оюутны лавлагаа, тодорхойлолтын төрөл, олгох нэгж, хугацаа

Лавлагаа, тодорхойлолт	Олгох алба	Хугацаа
Дунгийн тодорхойлолт	Бүрэлдэхүүн сургууль	Ажлын 1-3 хоног
Дипломын дүнгийн хавсралтыг багц цагт дүйцүүлсэн тодорхойлолт (Academic transcript)	Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар	Ажлын 5 хоног
АШУҮИС-ийн оюутны болон төгссөн тухай тодорхойлолт		Ажлын 1-3 хоног
Оюутны үнэмлэх нөхөн олгох	Оюутны хөгжил, удирдлагын газар	Ажлын 5 хоног
Диплом нөхөн олгох		Ажлын 14 хоног

### **Найм. Хариуцлага, журмын нэмэлт өөрчлөлт**

- 8.1. Энэхүү журмыг зөрчсөн бол хөдөлмөрийн тухай хууль, дотоод журам болон бусад дүрэм журамд заасан хариуцлага тооцно.
- 8.2. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Боловсрол хариуцсан проректор, ТӨСБЗГ, ОХУГ-ын саналыг үндэслэн Захиргааны зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

УХД0074 5845